

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 30-ний өдөр

Орхон аймаг

1. Үндсэн үйл ажиллагаа:

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ”, “Их шүтээн ОНӨААТҮГ” зэрэг байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

“Аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Хотын захирагчийн алба”, “Эрх бүжинхэн цэцэрлэг”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын 2025 оны 4 дүгээр улирлын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэж байна.

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

Албан хаагчид 2026 онд хариуцан ажиллах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлууллаа.

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ баримт материалыг байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажил 80%-тай хийгдэж байна.

2. Сургалт, зөвлөгөөн:

- 2026.01.22-ны өдөр Орхон аймгийн Татварын газраас зохион байгуулсан “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт” сэдэвт сургалтад байгууллагын 11 албан хаагч хамрагдлаа.



- 2026.01.22-ны өдөр Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран “AI зураг бүтээх, засварлах” сэдэвт дотоод сургалтыг зохион байгууллаа.



- 2026.01.30-ний Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас “Сэтгэцийн эрүүл мэндээ хайрлах нь” сэдэвт сургалт, бүлгийн ярилцлага хийлээ.



3. Үүрэг даалгавар:

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-01-16 үүрэг даалгавар:** Аймгийн Засаг дарга иргэдтэй хийх уулзалтын үеэр тухайн багтай холбоотой байгууллагуудаас иргэдэд өгөх мэдээ мэдээллийг аймгийн ЗДТГ-ын Мэдээллийн төвд хүргүүлэх:
Биелэлт: Багтай холбоотой иргэдэд өгөх мэдээ мэдээлэл байхгүй болно.
- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-01-16 үүрэг даалгавар:** Иргэд, аж ахуй нэгж байгууллагууд ойр орчмын 50 метр хүртэлх талбайн цас мөсийг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах:

Биелэлт: 2026.01.20-ны өдөр бүх албан хаагчид хуваарьт талбайн цас, мөсийг цэвэрлэлээ.



- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-01-23 үүрэг даалгавар:** Аймгийн Засаг дарга иргэдтэй хийх уулзалтын үеэр иргэдээс гарсан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх гарц гаргалгаа, шийдлийг гарган танилцуулах. Уг ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, 2027 онд хийгдэх уулзалтын үеэр төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулахад анхаарч ажиллах:

Биелэлт: Аймгийн Засаг дарга иргэдтэй хийх уулзалтын үеэр байгууллагын чиг үүрэгт хамааралтай асуудлаар иргэдээс санал хүсэлт гараагүй болно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР